



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 10 өдөр

Дугаар A158


Бор-Өндөр сум

**Газар эзэмших эрхийн гэрчилгээг  
хэсэгчлэн шилжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.2, 66.3 дахь заалт, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.3, 38.4 дэх заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийн гэрчилгээг хэсэгчлэн шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн, өргөдөл гаргасан иргэдийн газар эзэмших эрхийн гэрчилгээг Нэгдүгээр хавсралтад зааснаар шилжүүлсүгэй.
2. Газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэн авсан иргэдтэй гэрээ байгуулан, биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Газрын даамал / Т.Эрдэнэзаяа/-д үүрэг болгосугай.
3. Газар эзэмшүүлэх гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин, гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлж авсан иргэдэд үүрэг болгосугай.
4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Сумын Засаг даргын 2025 оны А/65 тоот захирамжийн иргэн А.Арвинжаргалд холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ОТГОНЦЭЦЭГ

Сумын Засаг даргын 2026 оны 03  
 дугаар сарын 10-ны өдрийн  
 А/58-р захирамжийн нэгдүгээр хавсралт

Газар болон эзэмшигчдийн мэдээлэл

д/д	Эрх шилжүүлэн авч буй иргэн, хуулийн этгээдийн нэр	Регистр	Газрын хэмжээ /м <sup>2</sup>	Эзэмших хугацаа	Газрын байршил хаяг	Нэгж талбарын дугаар	Зориулалт	Эрх шилжүүлж буй иргэн хуулийн этгээдийн нэр, регистр	Эрх шилжүүлэх үндэслэл
1	Боржигон Арсланбаатар Арвинжаргал	СФ78120801	972	8	1-р баг Бор-Өндөр, То Ван-1 гудамж, 107а тоот	2322002697	Үйлчилгээтэй орон сууц	Боржигон Арсланбаатар Арвинжаргал СФ78120801	Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээ 2025.07.25/0808
2	Булгадар Дашцэрэв Ганбат	СЕ75070911	88	8	1-р баг Бор-Өндөр, То Ван-1 гудамж, 103 тоот		Худалдаа үйлчилгээ		